



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А-335

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2 дахь заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-293 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1522012352

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн А.375
дугаар тушаалын хавсралт-2

**БАНКНЫ МОНГО УГААХ, ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ
ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААЛНД ЗАЙНААС ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монго угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк оорийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагаатай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд зайнаас хяналт тавихад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү зайны хяналтын зорилго нь банкнаас ирүүлсэн тайлан, мэдээнд үндэслэн тухайн банкны монго угаах терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх /цаашид МУТС/ҮОХЗ/ДС гэх/-тэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж, хяналт шалгалтын стратеги боловсруулан хэрэгжүүлэх, түүнд тулгуурлан хяналт шалгалтын төлөвлөгөө гаргах, газар дээрх хяналт шалгалтын чиглэл, хамрах хүрээ, давтамжийг тодорхойлох, зорчил дутагдал, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад оршино.

1.3. Зайнаас тавих хяналтын хүрээнд дараах ажлыг хийнэ:

1.3.1. Банкнаас тухайн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны цар хүрээ, газар зүйн байршил, онцлог, бүтэц, зохион байгуулалтад МУТС/ҮОХЗ/ДС-тэй тэмцэх эрсдэлийн удирдлага, бодлого журам нь нийцсэн эсэх, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цуглуулах, гаргуулан авах;

1.3.2. Банкны МУТС/ҮОХЗ/ДС-тэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээний тайлан гаргах;

1.3.3. Банк тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, бусад хүчин зүйлсийг харгалзан тухайн банкны хяналт шалгалтын стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

1.3.4. Банкны МУТС/ҮОХЗ/ДС-тэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар тайлан, мэдээ гаргуулан авч дүгнэлт хийх, биелэлтийг хангуулах;

1.3.5. Зайны хяналтын тайлан бэлтгэх, үр дүнд үндэслэн эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулах;

1.3.6. Банканд МУТС/ҮОХЗ/ДС-ийн эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор заавар, зөвлөмж гаргах.

**ХОЁР. ЗАЙНААС ХЯНАЛТ ТАВИХАД АШИГЛАХ ТАЙЛАН, МЭДЭЭ
ЦУГЛУУЛАХ**

2.1. Банкны МУТС/ҮОХЗ/ДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж, эрсдэлийн үнэлгээ хийхэд дараах тайлан мэдээг ашиглана:

2.1.1. Банкны МУТС/ҮОХЗ/ДС-тэй тэмцэх үйл ажиллагааны “Эрсдэлийн үнэлгээний матриц” /Энэ журмын нэгдүгээр хавсралт/;

2.1.2.Эрсдэлийн үнэлгээний матрицад ашиглах “Тоон өгөгдлийг цуглуулах маягт” /Энэ журмын хоёрдугаар хавсралт/;

2.1.3.Эрсдэлийн үнэлгээний матрицад ашиглах “Хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга” /Энэ журмын гуравдугаар хавсралт/;

2.1.4.Нийт хяналт шалгалтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан;

2.1.5.Банкны ТУЗ-д танилцуулсан МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлангийн хуулбар;

2.1.6.Банкны дотоод болон Монгол улсын хууль тогтоомжийн дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаар баталгаажуулсан хөндлөнгийн аудитын тайлан, тэдгээрийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдлын тайлан;

2.1.7.Банкны өөрийн МУТС/ҮОХЗДС эрсдэлийг үнэлсэн тайлан;

2.1.8.Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс үүсэж болзошгүй МУТС/ҮОХЗДС эрсдэлийг хэрхэн үнэлэх, удирдах талаар банкны авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

2.1.9.НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтийн тайлан;

2.1.10.Банкнаас ирүүлсэн бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан, сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, тайлангийн чанар /хуульд заасан хугацаанд мэдээлж байгаа эсэх, тайланд агуулагдах мэдээлэл бүрэн эсэх/, сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулга, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг гаргаж өгсөн байдал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй гүйлгээг хугацаанд нь түдгэлзүүлж ажилласан эсэх талаар Санхүүгийн мэдээллийн алба /цаашид СМА гэх/-наас ирүүлсэн мэдээ;

2.1.11.Монголбанкны хянан шалгагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан бусад баримт, мэдээ, мэдээлэл;

2.2.Банк нь энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.6-д заасан болон гадаад улсад явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор гадаадын хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, авсан арга хэмжээний талаарх тайлан мэдээ, мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бэлтгэж, дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Монголбанканд ирүүлнэ.

2.3.Банк нь энэ журмын 2.1.4, 2.1.5, 2.1.7, 2.1.8, 2.1.9-г заасан тайлан, мэдээг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор Монголбанканд ирүүлнэ.

2.4.Монголбанк нь энэ журмын 2.1.10-г заасан мэдээ дүгнэлтийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор СМА-аас гаргуулж авна.

2.5.Хянан шалгагч нь тайлан, холбогдох мэдээллийг банкны удирдлага баталгаажуулан, батлагдсан маягт, зааврын дагуу хугацаанд нь бүрэн ирүүлсэн эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

2.6.Хянан шалгагч нь банкнаас ирүүлсэн тайлан, баримт, мэдээллийг холбогдох журмын дагуу бичиг хэргийн бүртгэлд бүртгүүлж, материалыг банкны хувийн хэрэгт хавсарган, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

2.7.Хянан шалгагч нь энэ журмын нэгдүгээр хавсралт буюу “Эрсдэлийн үнэлгээний матриц”-ын тооцооллод ашиглах харьцаа, хувийн жин, хоёрдугаар хавсралт буюу “Тоон өгөгдлийг цуглуулах маягт”, гуравдугаар хавсралт буюу “Хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга”-ын оновчтой, үр дүнтэй

байдалд үнэлэлт дүгнэлт хийж ажиллана.

2.8.Зайнаас тавих хяналт нь тасралтгүй хийгдэх бөгөөд банкны үйл ажиллагаанд мэдэгдэхүйц оорчлолт гарсан тохиолдолд эрсдэлийн үнэлгээнд тусгаж, өөрчлөлт оруулна.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН ГАРГАХ

3.1.Банкны МУТС/ҮОХЗДС-тэй холбоотой эрсдэлийг жилд нэг удаа үнэлнэ.

3.2.Банкны эрсдэлийн үнэлгээг хийхдээ энэ журмын 2 дугаар бүлэгт заасан мэдээ, мэдээллийг ашиглах бөгөөд шаардлагатай гэж үзвэл үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээ, холбогдох бусад мэдээллийг ашиглаж болно.

3.3.Хянан шалгагч нь цуглуулсан тайлан мэдээ, мэдээллийг ашиглан банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх эрсдэлийн үнэлгээг 2.1.1-т заасан эрсдэлийн үнэлгээний матрицын дагуу 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор банк бүрээр үнэлж, дорөвдүгээр хавсралт “Банкны МУТС/ҮОХЗДС эрсдэлийн үнэлгээний тайлан гаргах маягт”-ын дагуу үнэлгээний тайланг гаргана.

3.4.Журмын 3.3-т заасан эрсдэлийн үнэлгээний тайланг 1 дүгээр улиралд багтаан удирдлагад танилцуулна.

3.5.Хяналт шалгалтын арга хэмжээ, шинээр гарч буй чиг хандлага, анхаарал татахуйц эрсдэлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг дараагийн эрсдэлийн үнэлгээнд тусгана.

3.6.Хянан шалгагч эрсдэлийн үнэлгээний аргачлалыг жилд нэг удаа шалгах бөгөөд эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэн сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээг авч болно.

3.7.Хянан шалгагч нь банк тус бүрд эрсдэлийн хувийн хэрэг хөтөлнө.

ДӨРӨВ. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ДАГУУ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1.Зайнаас тавих хяналтын үр дүнд үндэслэн эрсдэлд суурилсан хэлбэрээр газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

4.2.Газар дээрх хяналт шалгалтын давтамж, цар хүрээ, хяналт шалгалтын хамрах хугацаа, бусад хүчин зүйлсийг эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн гаргана.

4.3.Хянан шалгагч нь банк тус бүрийн МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх чиглэлээр хийх хяналт шалгалтын стратегийг тавдугаар хавсралтад заасан маягтын дагуу боловсруулан, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулна.

4.4.Эрсдэлийн үнэлгээний үр дүн, хяналт шалгалтын стратегийг харгалзан дараах хүснэгтэд заасны дагуу газар дээрх хяналт шалгалтыг хийж болно. Үүнд:

Матрицын үнэлгээ\ Шалгалтын хэлбэр	Маш ондор (4-5)	Ондор (3-4)	Дунд (2-3)	Бага (1-2)	Маш бага (0-1)
Давтамж	Жилд 1 удаа	2 жилд 1 удаа	3 жилд 1 удаа	Сэдэвчилсэн шалгалт	Сэдэвчилсэн шалгалт
МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх хяналтын уулзалт	Жил бүр	Жил бүр	2 жилд 1 удаа	Сэдэвчилсэн шалгалт	Сэдэвчилсэн шалгалт
МУТС/ҮОХЗДС-	Хагас	Хагас	Жил	Жил бүр	Жил бүр

тэй тэмцэх мэдээллийн чанарын шалгалт	жилд 1 удаа	жилд 1 удаа	бүр		
Хэрэгжилт хариуцсан ажилгны хяналт	Байнгын	Байнгын	Жилд 1 удаа	2 жилд 1 удаа	2 жилд 1 удаа

4.5.Банканд хяналт шалгалтын стратегийг хэрэгжүүлэхдээ дараах хяналт шалгалтын арга хэрэгслийг ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд хуульд заасан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хяналт шалгалтын арга хэрэгслийг тухайн банкны эрсдэлийн зэрэглэлээс хамаарч дангаар нь эсвэл хослуулан хэрэглэж болно.

4.6.Эрсдэлийг таних, тодорхойлох чиглэлээр дор дурдсан арга хэрэгслийг ашиглана:

4.6.1.МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэхтэй хамаарал бүхий мэдээллийг цуглуулах;

4.6.2.ТУЗ эсвэл гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтантай уулзалт хийх;

4.6.3.Шинээр үүсэж байгаа эрсдэл, чиг хандлагын талаар байнгын ажиглалт хийх, хяналт тавих;

4.7.МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх систем болон хяналтыг үнэлэхдээ дор дурдсан арга хэрэгслийг ашиглана:

4.7.1.МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх эрсдэлийн удирдлагын хяналтын асуулга авах;

4.7.2.ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны хангалттай байдлыг үнэлж дүгнэх;

4.7.3.Бодлого, журмын нийцтэй байдлыг үнэлэх;

4.7.4.Дотоод болон хөндлөнгийн аудитын тайлангаар танилцах;

4.7.5.ТУЗ, удирдах албан тушаалтан зэрэг өөр өөр чиг үүрэг бүхий ажилтнуудтай ярилцлага хийх;

4.7.6.Банканд тусгайлан хяналт шалгалт хийх/хяналт тавих;

4.7.7.Сэдэвчилсэн шалгалт хийх/хяналт тавих;

4.7.8.Омнох шалгалтаар илэрсэн зорчил дутагдлыг арилгасан эсэхийг хянах;

4.7.9.Таниулах, сургах, сурталчлах.

4.8.Газар дээрх хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг хяналт шалгалтын стратеги болон эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн жил бүрийн эхний улиралд багтаан боловруулж, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулан батлуулна.

4.9.Газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд Хяналт шалгалтын газар хяналт тавьж ажиллана.

4.10.Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр хяналт шалгалтын стратеги болон төлөвлөгөөнд оорчлолт оруулж болно.

ТАВ. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ БЭЛТГЭХ, ТАЙЛАГНАХ

5.1.Хянан шалгагч нь жилд нэг удаа банк тус бүрийн зайны хяналтын тайланг гаргана.

5.2.Зайнаас тавих хяналтын дүгнэлтэд дараах зүйлсийг тусгана:

5.2.1.Энэ журмын 2.1.2 болон 2.1.3-т заасан тоон өгөгдөл, асуулгыг ашиглан банк тус бүрийн МУТС/ҮОХЗДС эрсдэлийг үнэлсэн эрсдэлийн үнэлгээний матрицын үнэлгээ;

5.2.2.Банкны МУТС/ҮОХЗДС эрсдэлийн үнэлгээнд гарсан өөрчлөлт, түүний шалтгаан, эрсдэлийг өсгөж байгаа гол хүчин зүйлс;

5.2.3.Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх бодлого, журмын дутагдалтай тал, анхаарвал зохих асуудлууд;

5.2.4.Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг бууруулах зорилгоор өгсөн үүрэг даалгавар, тэдгээрийн хэрэгжилт, авсан арга хэмжээ;

5.2.5.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, МУТС/ҮОХЗДС эрсдэлийг бууруулах зорилгоор банктай ажиллах хяналт шалгалтын стратеги;

5.2.6.Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

5.2.7.Банк, түүний удирдлагад хариуцлага ногдуулах талаар санал байгаа тохиолдолд авах арга хэмжээний талаарх үндэслэл бүхий дүгнэлт.

5.3.Зайны хяналтын тайланг дараа оны эхний улиралд багтаан Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлд танилцуулна.

ЗУРГАА. ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ОРОЛЦООГ ХАНГУУЛАХ, СУРГАХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

6.1.Хянан шалгагч нь Монголбанкнаас баримтлах МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх хяналт шалгалтын стандартыг таниулах, салбарын хэмжээнд шинээр үүсэж байгаа эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, эргэх холбоотой ажиллах, сургах, соён гэгээрүүлэх, МУТС/ҮОХЗДС-тэй үр дүнтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх талаар эерэг хандлагыг төлөвшүүлэхэд банканд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж болно.

6.2.Сургах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.2.1.Сургалт болон соён гэгээрүүлэх ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

6.2.2.Сургалт болон соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах;

6.2.3.Сургалт болон соён гэгээрүүлэх ажлын үр дүнг тайлагнах;

6.2.4.Хянан шалгагч нь МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх чиглэлээр банканд гарч байгаа нийтлэг зөрчил дутагдал, МУТС/ҮОХЗДС эрсдэлийг харгалзан гарын авлага гаргаж, заавар зөвлөмж өгч болно.

6.3.Шаардлагатай тохиолдолд хянан шалгагч нь банкуудтай тухайлсан чиглэлээр уулзалт зохион байгуулах, судалгаа авах, саналыг сонсох, эргэх холбоо үүсгэх, хариу арга хэмжээ авах, баримталж буй бодлого, журмыг тайлбарлах, сурталчлах зэргээр хамтран ажиллаж болно.

6.4.Энэ журмын 6.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 жилд 1 удаа гаргаж, төлөвлөгөөний биелэлтийг удирдлагад танилцуулна.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1.Энэхүү журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

7.2.Банкны МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт нь энэ журамд заасан үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй.

_____оОо_____